

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН**

**“МОНГОЛ АМАН БОЛОН БИЧГИЙН
ЗОХИОЛЫН ТҮҮХ, УРАН САЙХНЫ ТӨЛӨВ,
ХЭРЭГЛЭЭ”**

**СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ТАЙЛАН
(2017-2019)**

**УЛААНБААТАР ХОТ
2020 ОН**

Улсын бүртгэлийн дугаар

Нууцын зэрэглэл: Б

.....

Суурь судалгааны сэдэвт ажил
Гэрээний дугаар: ШуСс 2017/68

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН**

**“МОНГОЛ АМАН БОЛОН БИЧГИЙН ЗОХИОЛЫН ТҮҮХ, УРАН
САЙХНЫ ТӨЛӨВ, ХЭРЭГЛЭЭ”**

СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ТАЙЛАН
(2017-2019)

Суурь судалгааны төслийн удирдагч:

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
салбарын эрхлэгч, Хэлбичгийн
шинжлэх ухааны доктор, профессор
С.Байгалсайхан

*Санхүүжүүлэгч байгууллага:
Захиалагч байгууллага:*

Шинжлэх Ухаан Технологийн Сан
Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан,
Спортын Яам

Тайлан өмчлөгч:

Шинжлэх Ухааны Академийн
Хэл зохиолын хүрээлэн

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН**



**“МОНГОЛ АМАН БОЛОН БИЧГИЙН ЗОХИОЛЫН ТҮҮХ, УРАН
САЙХНЫ ТӨЛӨВ, ХЭРЭГЛЭЭ”**

**СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ТАЙЛАН
(2017-2019)**

Суурь судалгааны төслийн удирдагч:

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
салбарын эрхлэгч, Хэлбичгийн
шинжлэх ухааны доктор, профессор
С.Байгалсайхан

**Улаанбаатар
2020**

ГАРЧИГ

1. Суурь судалгааны төслийн танилцуулга
2. Төсөлт ажлын зорилго, гүйцэтгэх үндэслэл, шаардлага
3. Сэдвийн хамарсан хүрээ
4. Бүтэц зохион байгуулалт
5. Төсөлт ажлын судлагдсан байдал
6. Төсөлт ажлын санхүүжилт
7. Төслийн ерөнхий үр дүн
8. Төслийг хэрэгжүүлсэн үндсэн чиглэл
9. Эцсийн үр дүнгийн талаарх төсөөлөл, шинэлэг буюу дэвшилттэй тал
10. Эдийн засаг, нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол
11. Үр дүнг шилжүүлэх, борлуулах, ашиглах боломж, төслийн өртгийг нөхөх урьдчилсан тооцоо, хугацаа (бусдад худалдах, лицензийн гэрээгээр ашиглуулах, төсөл, сэдэвт ажлыг санаачлагч өөртөө үлдээх гэх мэт)
12. Өртөг зардлыг тооцсон товчоо, түүний задаргаа, захиалагчаас гаргах хөрөнгийн хэмжээ, холбогдох бусад материал
13. Лаборатори, туршилтын бааз
14. “Монгол аман болон бичгийн зохиолын түүх, уран сайхны төлөв, хэрэглээ” сэдэвт ажлын үр дүн

1. СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА:

1. Сэдэвт ажлын:

1.1. Нэр: “МОНГОЛ АМАН БОЛОН БИЧГИЙН ЗОХИОЛЫН ТҮҮХ, УРАН САЙХНЫ ТӨЛӨВ, ХЭРЭГЛЭЭ”

1.2. Хугацаа (эхлэх, дуусах он, сар): 2017 оны 4-р сарын 1-нээс
2019 оны 12-р сарын 31

1.3. Захиалагч (дэвшүүлэгч): БСШУСЯ

1.4. Гүйцэтгэгч: ШУА, Хэл зохиолын хүрээлэн

1.5. Санхүүжүүлэх этгээд: Шинжлэх ухаан технологийн сан

1.6. Нийт зардал (мян.төг): 35,000,0 мянган төгрөг

1.7. Удирдагчийн овог, нэр, албан тушаал, мэргэжил, боловсролын болон эрдмийн зэрэг, цол;

Санжаагийн БАЙГАЛСАЙХАН: ШУА, ХЗХ-ийн Утга зохиолын секторын эрхлэгч, ЭШТА, доктор (Sc.D), проф

1.8. Оролцогчдын овог, нэр, албан тушаал, мэргэжил, боловсролын болон эрдмийн зэрэг цол, төсөлд тэдний оролцох хэлбэр (үндсэн болон туслан гүйцэтгэгч, гэрээгээр ажиллах гэх мэт).

Далантайн Цэрэнсодном	ШЗ 37040115	Академич, ЭШТА, үндсэн гүйцэтгэгч
Аюушжавын Алимаа	ЧП 67060111	Доктор /Ph.D/, ЭШДА, үндсэн гүйцэтгэгч
Түдэвийн Баясгалан	АГ 77051611	Доктор /Ph.D/, ЭШДА, үндсэн гүйцэтгэгч
Баасанжаргалын Дайриймаа	УС 74092301	Доктор /Ph.D/, ЭШДА, үндсэн гүйцэтгэгч
Чулууны Заяасүрэн	КЗ 75032106	Доктор /Ph.D/, ЭШДА, үндсэн гүйцэтгэгч
Ганболдын Батмөнх	НК 93072016	Магистр, ЭШДаА, үндсэн гүйцэтгэгч
Доржпаламын Сумьяа	ЧС 57081106	Доктор /Ph.D/, ЭШТА, үндсэн гүйцэтгэгч
Ринчинбаатарын Отгонбаатар	ХЖ 55032570	ЭШДА, үндсэн гүйцэтгэгч
Дагнямын Мөнх-Отгон	АН 84122404	Магистр, ЭШДаА, үндсэн гүйцэтгэгч
Хүрэлбаатарын Бирасүрэн	ЧС 76050418	Магистр, ЭШДаА, үндсэн гүйцэтгэгч
Даваажавын Буянбаатар	АК 91122116	Магистр, ЭШДаА, үндсэн гүйцэтгэгч
Анандын Амарсанаа	ЦЗ 76040604	Доктор /Ph.D/, ЭШДА, үндсэн гүйцэтгэгч
Гаадамбын Билгүүдэй:	ХЖ 63012398	Доктор /Ph.D/, проф, ЭШТА, үндсэн гүйцэтгэгч
Доржсүрэнгийн Болормаа	ЦГ 67090642	Доктор /Ph.D/, ЭШАА, үндсэн гүйцэтгэгч
Баатаржавын Мөнхбаяр	ЧЕ 74012716	Доктор /Ph.D/, ЭШАА, үндсэн гүйцэтгэгч
Дэмбэрэлсүрэн Цэвээндорж	НЫ 78012571	Доктор /Ph.D/, ЭШДЭА, үндсэн гүйцэтгэгч
Жамбаагийн Ууганбаатар	ЛЖ 80073116	Докторант, ЭШДЭА, үндсэн гүйцэтгэгч
Батмөнхийн Мөнх-Эрдэнэ	НИ 93091817	Магистр, ЭШДаА, үндсэн гүйцэтгэгч
Энхзаяагийн Оюунтунгалаг	ЙН 92121700	Магистр, ЭШДаА, үндсэн гүйцэтгэгч

2. ТӨСӨЛТ АЖЛЫН ЗОРИЛГО, ГҮЙЦЭТГЭХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА:

1. Монгол утга зохиолын бүтээлийг цогцолбор хүрээнд нь буюу аман зохиол, хуучин бичгийн зохиол, төвд хэлт монгол бичгийн зохиол, орчин үеийн утга зохиолын хөгжил, харилцан нөлөөлөл, уламжлал шинэчлэл, дүрслэл өгүүлэмжийн онолын асуудлыг судлах юм. Ингэхдээ монгол утга зохиолд тусгасан нийгэм гоо зүй уран сайхны олон талт дүрслэгдэхүүний хөгжил хувьсал, монгол ахуй дүрслэлээр хэрхэн баяжсаныг ялгаруулан тодруулах юм. Нөгөө талаар монгол аман зохиол, бичгийн зохиолын уран сайхны туурвил зүйн сэтгэлгээний өсөлт тэлэлтэд гадаад хүчин зүйл томоохон хэмжээгээр нөлөөлсөн байдаг билээ. Энэ үйл явцыг зохиол бүтээлийн тусагдахууны хувьсал, уламжлал шинэчлэлийн залгамж холбоо нь хамгийн тод харуулдаг ба туурвил зүйн энэ чухал элементийг нэг нэгээс урган гарсан шалгаант холбоо, нөхцөл байдал, залгамж чанар дунд нь, нэгийг нөгөөгөөс үл салгасан явцуу хүрээнд бус аман ба бичгийн зохиолын цогц байдалд судлах хэрэгтэй юм. Ийм учраас бид энэхүү суурь судалгааны сэдэвт ажлаараа аман болоод монголын эртний бичгийн зохиол, төвд хэлт уран зохиол, орчин үеийн уран зохиолд харилцан шалгаант байдалд оршдог үзэгдлийг задлан шинжлэх юм.
2. Өнөөгийн цаг үе, нийгмийн шаардлага нь бүх нийтийн утга зохиолын боловсролыг ахиулах хэрэгцээнд суурилсан, уншигч, судлаачдын хүсэл сонирхолд нийцсэн, шинжлэх ухааны тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн байхад чиглэж байна. Тэгвэл бидний гүйцэтгэх “Монгол аман болон бичгийн зохиолын түүх, уран сайхны төлөв, хэрэглээ” сэдэвт ажил нь энэхүү шаардлагыг харгалзан, үндэсний утга зохиол, иргэний нийгмийн соёлыг хамтад нь эзэмших хүсэл сонирхолд нийцсэн, соён гэгээрлийн мэдлэг боловсрол, мэдээллийг иргэд ард түмэн өөрсдөө тээхэд чиглэсэн судалгаа байх юм.
3. Монгол утга зохиолыг бүс нутгийн хүрээнд нь, дүрслэгдэхүүн тусагдахуун, өгүүлэмжийн хөгжил хувьслыг тодорхой онцлог шинжээр нь илэрхийлэх, улмаар туурвил зүйн үндэсний хэв маяг, түүний өвөрмөц онцлогийг тодруулах шаардлага уг судалгааны ажлын гол үндэслэл болно. Энэ судалгааны ажлыг хийж гүйцэтгэснээр монголын утга зохиол нь бусдыг даган дуурайсан, хуулсан гэх зарим буруу үзэлтийг няцааж, монголчуудын уран сайхны сэтгэлгээний түүхийн хөгжлийн явцыг тодруулахад бас нэгэн дэвшил болох юм.
4. Даяаршил, баруунжилт, техникжилтийн нөхцөлд монголчуудын үндэсний ухамсар, соёлын хэрэгцээ өндөрсөж, сэргэж буй өнөө цагт уламжлалт аман ба бичгийн зохиол, зан үйлийн зүйлийг судалгааны түвшинд тэтгэн дэмжиж, нүүдэлчдийн утга зохиол, аман зохиолын бодит баримтаас нийгмийн шинэ нөхцөлд баримтлах монгол соёлын бодлогыг тодоройлохуйц бүтээл нэн хэрэгцээтэй байгаа юм.

3. СЭДВИЙН ХАМАРСАН ХҮРЭЭ:

Бидний гүйцэтгэсэн энэхүү суурь судалгаа нь: Монгол ардын аман зохиол, Монголын хуучин бичгийн уран зохиол, Дундад зууны үеийн уран зохиол, түүний дурсгалууд, Монголын орчин үеийн уран зохиолыг бүхэлд хамарсан, эдгээрийг Монголын уран зохиол гэсэн нэгдсэн тогтолцоонд авч үзсэн юм.

Тус сэдэвт ажил нь Монголын эрт ба эдүгээгийн уран зохиолын хөгжилд үндэслэлд тусгагдсан шаардлагын үүднээс хамарч хийгдсэн ба дараах материалыг үндсэн хэрэглэгдэхүүн болгон ашигласан юм. Үүнд:

1. Монголын түүхэн уран зохиолын гол гол бүтээл болох “Монголын нууц товчоо”, “Алтан товч”, “Эрдэнийн эрих”, “Болор эрих”, “Болор толь”, “Асрагч нэртийн түүх”, “Шар тууж” зэрэг томоохон бүтээлүүд болон XIII-XVIII зууны үеийн богино хэлбэрийн олон бүтээлүүд нь нэг талаас түүхийн бүтээл, нөгөө талаас уран зохиолын дурсгал, гурав дахь талаасаа Монгол хэлний дундад үеийн дурсгал гэсэн хам шинжтэй (синкретик) дурсгалууд
2. Монголын бурхны шашны уран зохиолын төрөл зүйлд хамаарах тахил төгсгөлийн шүлэг, монгол уншлагын магтаал, сургаалийн шүлэг дуулал, гүр дуунууд
3. Монголын ард түмний олон зууны турш өвлүүлэн уламжилж ирсэн арвин баялаг сан хөмрөг, урын сангаас харилцаа дууны төрөл, уран яруу хэллэгт ерөөл, магтаалууд
4. XX зууны Монголын уран зохиолыг үүсгэн хөгжүүлэгч нарын бүтээл туурвилууд
5. Монголын уран зохиолын судлалын бусад бүтээл, ганц сэдэвт судалгааны бүтээл гадаадын эрдэмтэн судлаачдын бүтээл зэрэг бүтээл-мэдээллийн баялаг санг хамарсан байна.

4. БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

“Монгол аман болон бичгийн зохиолын түүх, уран сайхны төлөв, хэрэглээ” сэдэвт суурь судалгааг гүйцэтгэхийн тулд дараах зохион байгуулалтыг хийж ажиллав. Үүнд: Сэдэвт ажлын төсөлд тусгагдсан чиглэлээр эрдэм шинжилгээний ажилтан бүр гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, удирдамжаа боловсруулан батлуулж, хүрээлэнгийн захиргаа, удирдлагатай хөдөлмөр үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан байна.

5. ТӨСӨЛТ АЖЛЫН СУДЛАГДСАН БАЙДАЛ:

Монгол аман зохиол, бичгийн зохиолын тогтолцоотой судлал хөгжөөд олон зууныг үджээ. Монгол аман ба бичгийн зохиол, монголын уран зохиолын түүх, уран сайхны төлөв хэрэглээний асуудлыг нээлтийн төвшинд тодруулсан олон эрдэмтний дорвитой бүтээлийн томоохон сан бидэнд уламжлагдан үлдсэн. Ахмад эрдэмтэн судлаачдын туурвисан эдгээр бүтээлийн баялаг уламжлалд тулгуурлан, утга зохиол, уран сайхны сэтгэлгээний хөгжлийн түүхийг нэгдсэн тогтолцоонд авч үзэж, үнэт зүйлийг нь тодорхойлж, үнэлж дүгнэж байр суурийг эзлүүлж, зөвхөн Монголын уран зохиол бус нийт монгол туургатан хийгээд өрнө, дорнын соёлын нэгдмэл харилцаа хүрээнд уламжлал шинэчлэлийн хандлага, явцыг

тодруулж өгөх болно. Монголын аман ба бичгийн зохиолын хүрээнд шинжлэх ухааны тогтолцоотой уран зохиолын онол, түүх, судлалын толь бичиг хараахан хийгдээгүй тул “Монгол аман болон бичгийн зохиолын түүх, уран сайхны төлөв, хэрэглээ” сэдэвт ажлын хүрээнд “Монгол утга зохиолын нэвтэрхий толь” хэмээх бүтээлийг туурвиж байна. Иймийн учир эдүгээ нийгэм цаг үеийн шаардлага, орчин үеийн шинжлэх ухааны хөгжлийн ололт, өнөөгийн төвшин, үр дүнг тусгасан шинэлэг суурь судалгаагаар Монголчуудын бүтээсэн утга соёл, уран зохиолын зүйлийн сэтгэлгээний уламжлал, шинэчлэлийг асуудлыг тодорхойлж байгаагаараа зайлшгүй хэрэгцээтэй суурь судалгаа болж байгаа юм.

6. ТӨСӨЛТ АЖЛЫН САНХҮҮЖИЛТ:

Нийт зардал: 35, 000, 0 мянган төгрөг

7. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ ҮР ДҮН:

“Монгол аман болон бичгийн зохиолын түүх, уран сайхны төлөв, хэрэглээ” сэдэвт ажлын үр дүнг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. Монголын уран зохиолын түүхэн үндсийг бүхий л талаас нь тодруулсан учраас цаашдын судалгааны үндэслэл, хүрээг өргөтгөх боломжийг олгож байна.
2. Эрдэм шинжилгээний болоод сургалтын хэрэгцээ шаардлагыг хангасан, судалгааны шинэ баримт, хэрэглэгдэхүүн гаргаж, дүгнэлт дэвшүүлсэн бүтээлүүд гарсан нь нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, тулгамдсан асуудлыг шийдсэн бүхэлдээ шинжлэх ухаан, нийгэм, соёл уран сайхны суурь судалгааны төвшний ажил болж чадсанд оршино.
3. Монголын эртний уран зохиол судлалын хүрээнд хийсэн судалгааны ажлын ололт, гол үр дүн нь “Монголын бурханы шашны уран зохиол - III” бүтээлийг хэлж болно. Эл бүтээлээс Монголын бурханы шашны уран зохиолын Тахил төгсгөлийн шүлэг, Монгол уншлагын магтаал, Сургаалийн шүлэг дуулал, Гүр дууны төрөл зүйл хэрхэн хөгжсөн, туурвил зүйн ямар арга барилаар бүтээн туурвидаг, нийгэм уран сайхан, гоо зүйн үнэлэмж үнэлгээг хэрхэн шингээн бичдэг ... зэрэг бүх талын судалгааны мэдээллийг олж авч болох бөгөөд энэ үүднээсээ бүх шатны сургалт судалгаанд хэрэглэгдэх хийгээд нийт ард түмний утга зохиолын боловсролыг дээшлүүлэхэд үнэт хэрэглэгдэхүүн болсон юм.
4. Монголын орчин үеийн уран зохиол судлалын хүрээнд хийсэн судалгааны ажлын ололт, гол үр дүн нь “Реализм ба XX зууны Монгол роман” хэмээх бүтээлийг хэлж болно. XX зуунд зуугаар тоологдох монгол роман гарсны дотор Б.Ринчен, Д.Намдаг, Ч.Лодойдамба нарын туульс онцгой байр суурь эзлэх тул тэдгээрийг реализмын арга урсгалтай холбон гүнзгийрүүлэн шинжилжээ. Л.Түдэв, С.Удвал, Ж.Пүрэв, С.Дашдооров, Ж.Бямба нарын арав гаруй зохиолчийн романыг сэдэв, дүр дүрсэлгээ тэргүүтний үүднээс задлан шинжилж, Ц.Хасбаатар, С.Лувсанвандан, Д.Цэнд, Ц.Мөнх, Г.Жамсранжав, Г.Ринчинсамбуу, Ч.Билигсайхан нарын зэрэг судлаачдын тухайлсан зохиолын талаарх үзэл бодолд өөрийн нотолгоо баталгааг ул үндэстэйгээр нээн тодруулсан байна.

8. ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮНДСЭН ЧИГЛЭЛ:

1. Монголын эрт, эдүгээгийн уран зохиолын дурсгал, гол гол төлөөлөгчдийн бүтээлүүдэд онол туурвил зүй, бичвэрийн, болон түүхэн харьцуулсан чиглэлээр онолын судалгаа хийсэн.

2. Монголын утга зохиолын түүх, онол туурвил зүй, зүй тогтол, намтар судлал, бичвэрийн асуудлыг хөндсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, ганц сэдэвт зохиол бичсэн.

3. Монголын утга зохиолд хүн төрөлхтний нийтлэг сэтгэлгээ, утга зохиолын түгээмэл онолын үүднээс орчин үеийн арга барилаар задлан шинжилгээ хийж, нийгэм уран сайхан, гоо зүйн мөн чанарыг тодруулахад чиглэгдсэн болно.

9. ЭЦСИЙН ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ТӨСӨӨЛӨЛ, ШИНЭЛЭГ БУЮУ ДЭВШИЛТТЭЙ ТАЛ:

1. Өмнөх үеийн судалгааны ажлын ололт, уламжлал дээр тулгуурлан, мэдээллийг шинэлэг загвараар боловсруулан баяжуулж, судалгааны үр дүнгийн түгээлтийн төвшинг буюу онолын мэдлэгийг амьдрал практикт нэвтрүүлэх, хэрэглээтэй нийцүүлсэн байдлыг ахиулсан чанартайгаараа ялгарна.

2. Хэдийгээр нийгмийн оюун санааны амьдралд чухал хэрэгцээтэй авч, тэр бүр түгэн дэлгэрч чаддаггүй, зөвхөн уран зохиол судлал, хэлбичгийн ухааны онол туурвил зүйн хүрээнд байдаг ойлголтыг шинэ бүтээмж, шинэлэг хэлбэрээр нийтэд түгээж, эдийн засгийн эргэлтэд оруулж, хүн ардаа соён гэгээрүүлэхэд чухал алхам болно. Энэ байдал нь хэлбичгийн ухааны бусад судалгааны бүтээлээс хэрэглэгчийн хүсэл сонирхолд нийцсэн инноваци болж байгаагаараа шинэлэг, дэвшилттэй талтай.

10. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БОЛОН ШИНЖЛЭХ УХААНЫ АЧ ХОЛБОГДОЛ:

1. Дэлхийн улс орнуудад аливаа шинжлэх ухааны онолын ойлголт, суурь мэдлэгийг хамгийн энгийн, хялбар байдлаар тайлбарлан, ард түмнийхээ соён гэгээрэл, танин мэдэхүйд чухал хувь нэмэр оруулсан олон бүтээл байдаг. Монгол орны хувьд байгалийн шинжлэх ухааны түгээмэл чанартай салбарын мэдлэгийг өгүүлсэн гадаадын бүтээлийг орчуулан нэвтрүүлсээр байна. Харин бидний “Монгол аман болон бичгийн зохиолын түүх, уран сайхны төлөв, хэрэглээ” сэдэвт ажлын бүрэлдэхүүнд буй бүтээлийн хувьд гадаадаас орчуулах боломжгүй зөвхөн бидний бүтээх ёстой, үндэсний чанартай, Монгол орны өнөөгийн нийгэм цаг үед нийцсэн үнэт зүйлийг дэвшүүлэн түгээж, бүх ард түмний утга зохиолын боловсролд хувь нэмэр оруулж байгаагаараа шинжлэх ухаан, нийгмийн ач холбогдолтой.

2. Хэлбичгийн ухаан, уран зохиол судлалын онолын ойлголтыг хялбар байдлаар таниулсан уг бүтээлийг сургалт, судалгааны түгээмэл орчинд ашиглан, хэрэглэж, дараагийн бүтээл гарах уламжлал бий болж байгаагаараа шинжлэх ухааны ач холбогдолтой.

3. Үндэсний уран зохиол болон дэлхийн уран зохиолын талаарх нээлттэй нийгэм, нийгэм цаг үед нийцсэн сонирхолтой баримт, мэдээлэл бүхий “Монгол аман болон бичгийн зохиолын түүх, уран сайхны төлөв, хэрэглээ”

сэдэвт ажил нь хэрэглээний өндөр ашиглалттай бүтээл болох тул эдийн засгийн ач холбогдолтой гэж үзэж байна.

4. Монголчуудын олон мянган жилийн хуримтлуулсан амьдралын туршлага нь тэдний бүтээсэн соёл урлаг, хөдөлмөр, аж ахуйд туссан байдаг бөгөөд энэ нь уламжлал, зан үйл, ёс заншил, ёслол, шүтлэг бишрэл нь аман ба бичгийн зохиолдоо гүнзгий тусгалаа олсон байх ийм хосолсон асуудлыг төрөл зүйл тус бүрийн туурвил зүйн түвшинд судлан тодорхойлсноор монголчуудын аж байдал, ертөнцийг үзэх үзэл, зан үйлийн дадал хэвшил уран сайхны аман бүтээлээр хэрхэн дамжин илэрсэн байдлыг танин мэдэх бололцоо бүрдэх юм. Тиймээс шинжлэх ухаан, танин мэдэхүй, гоо сайхан, ёс зүй, хүмүүжлийн ач холбогдолтой судалгаа болно. Өөрөөр хэлбэл аман ба бичгийн зохиолын үнэ цэн, дотоод ахуй ертөнцөд нэвтэрч илрүүлэх зорилго тавьж байгаагаараа шинжлэх ухааны ач холбогдол нь тодорхойлогдох юм.

11. ҮР ДҮНГ ШИЛЖҮҮЛЭХ, БОРЛУУЛАХ, АШИГЛАХ БОЛОМЖ, ТӨСЛИЙН ӨРТГИЙГ НӨХӨХ УРЬДЧИЛСАН ТООЦОО, ХУГАЦАА (БУСДАД ХУДАЛДАХ, ЛИЦЕНЗИЙН ГЭРЭЭГЭЭР АШИГЛУУЛАХ, ТӨСӨЛ, СЭДЭВТ АЖЛЫГ САНААЧЛАГЧ ӨӨРТӨӨ ҮЛДЭЭХ ГЭХ МЭТ):

“Монгол аман болон бичгийн зохиолын түүх, уран сайхны төлөв, хэрэглээ”сэдэвт ажилд багтаж буй бүтээлүүд нь бүх нийтийн утга зохиолын боловсрол, ард түмний танин мэдэх соён гэгээрүүлэх сэтгэлгээнд тодорхой хувь нэмэр оруулж, цаг үе, нээлттэй нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээл болно гэдэгт итгэлтэй буй тул уг ажлыг хэвлэгдсэнээс эхлэн бусдад худалдах хэлбэрээр, мөн лицензийн гэрээний нөхцлөөр ашиглаж өртгөө нөхөх боломжтой.

Сэдэвт ажлын бодит үр дүнгээр хэвлэгдсэн бүтээлүүд нь судалгаа, шинжлэх ухааны үр дүн болж олон нийтийн оюуны хэрэгцээг хангах төдийгүй түүнийг дотоод, гадаадын эрдэмтэн судлаачид, оюутан сурагчид, сонирхогчдын эрэлтэд нийцсэн чанар, үзэмжтэй ном болон хэвлэгдэнэ.

Бүтээлүүдийг судалгаа шинжилгээ, их, дээд сургуулийн хичээлд ашиглах бүрэн боломжтой. Хэвлэгдэх номууд нь монгол утга зохиол судлал, аман зохиол, ардын өв соёл, уламжлалт зан заншлыг дэлхийд сурталчилсан оюуны бүтээл байх болно.

12. ӨРТӨГ ЗАРДЛЫГ ТООЦСОН ТОВЧОО, ТҮҮНИЙ ЗАДАРГАА, ЗАХИАЛАГЧААС ГАРГАХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ХОЛБОГДОХ БУСАД МАТЕРИАЛ:

№	Зардал	Оноор (мян.төг.)			
		2017	2018	2019	2017-2019
1	Эрдэм шинжилгээний	6,000,000	14,000,000	15,000,000	35,000,000
2	Нийт дүн	6,000,000	14,000,000	15,000,000	35,000,000

13. ЛАБОРАТОРИ, ТУРШИЛТЫН БААЗ;

Монголын үндэсний номын сан, Улаанбаатар хотын номын сан, хүүхдийн номын ордон, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Дуун ухааны хөмрөг, Монголын үндэсний Радио, телевизийн хөмрөг, Соёлын өвийн төв. Мөн гадаадын монгол аман зохиол, угсаатны зүйн холбогдох байгууллагын номын сан, сан, архивууд. Өөрчлөгдөн шинэчлэгдэж буй орчин үеийн нөхцөлд уламжлалт соёлын өв, түүний дотор ардын аман зохиолын судалгааны эх хэрэглэгдэхүүнийг баяжуулах, өнөөгийн байдлыг судлан тогтооход хээрийн шинжилгээний анги ажиллуулах шаардлагатай болно.

14. “МОНГОЛ АМАН БОЛОН БИЧГИЙН ЗОХИОЛЫН ТҮҮХ, УРАН САЙХНЫ ТӨЛӨВ, ХЭРЭГЛЭЭ” ТӨСЛИЙН ҮР ДҮН:

“МОНГОЛ АМАН БОЛОН БИЧГИЙН ЗОХИОЛЫН ТҮҮХ,
УРАН САЙХНЫ ТӨЛӨВ, ХЭРЭГЛЭЭ”
СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР

ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР

/Техникийн даалгавар/

№	Хүлээлгэн өгөх үр дүн (таамаглал, бүтээл, туурвил, арга зүй г.м.)	Тоо хэмжээ	Үр дүнгийн үндсэн үзүүлэлт	Үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа (он, сар)
1	“Аман зохиол судлал” эрдэм шинжилгээний сэтгүүл. 2017-2019 онд 3 дугаар гарна. А.Алимаа, Т.Баясгалан, Б.Дайриймаа, Ч.Заяасүрэн, Г.Батмөнх,	Бүгд: 45 хх /Нэг дугаарын хэмжээ 15 хх /	Монгол аман зохиол судлалын чиглэлээр тус сэдэвт ажлын явцын үрд бий болсон шинэ мэдлэг, мэдээлэл бүхий эрдэм шинжилгээний өгүүллүүдийг эл цувралдаа хэвлүүлнэ. <ul style="list-style-type: none"> • “Аман зохиол судлал” эрдэм шинжилгээний цуврал, Боть XXXVIII, дэвтэр 1-16, 208х, ISSN 2308-281X, 2017. • “Аман зохиол судлал” эрдэм шинжилгээний цуврал, Боть XXXIX, Дэвтэр 1-16, 303х, ISSN 2308-281X, 2018. • “Аман зохиол судлал” эрдэм шинжилгээний цуврал, Боть XL, Дэвтэр 1- 14. 208 х. ISSN 2308-281X, 2019. 	2017 оны III улирал 2018 оны III улирал 2019 оны III улирал
2	“Монгол аман яруу найргийн уламжлал ба хэрэглээ” цуврал. А.Алимаа, Т.Баясгалан, Б.Дайриймаа, Ч.Заяасүрэн, Г.Батмөнх	20 хх	Энэ чиглэлийн хүрээнд “Монгол дууны яруу найргийн үгийн сангийн судалгаа” /хамтын бүтээл/ гарна. <ul style="list-style-type: none"> • Ерөөлч, магтаалч Гомбын Оргойн өв”. - Эмхэтгэж удиртгал, тайлбар үйлдсэн Ч.Заяасүрэн. Редактор С.Байгалсайхан. “Соёмбо принтинг” ХХК-д хэвлэв. Уб., 2018, х.248. 20хх, ISBN 999788927-4, 2018. • “Монгол ардын харилцаа дуу”. -Эмхэтгэж, удиртгал, тайлбар хийсэн А.Алимаа, Б.Дайриймаа. Редактор Н.Лантуу. “Соёмбо принтинг” ХХК-д хэвлэв. Уб., 2019, 224 х. 14хх, ISBN 978- 9919-21-889-8 	2019 оны III улирал
3	“Жангарын шинэ судалгаа” Т.Баясгалан,	15 хх	Жангарын туулийн шинэ судалгааны бүтээл бий болно. <ul style="list-style-type: none"> • Т.Баясгалан. “Жангар” туулийн хувилбаруудын зэрэгцүүлсэн судалгаа” - 	2019 оны III улирал

			Редактор С.Байгалсайхан. “Соёмбо принтинг” ХХК-д хэвлэв. Уб., 2019, 124 х. 7,7хх, ISBN 978-99978-768-9-8	
4	“Төвд судлал” эрдэм шинжилгээний сэтгүүл. 2017-2019 онд 3 дугаар гарна. Д.Сумъяа, Р.Отгонбаатар, Д.Мөнх-Отгон, Х.Бираасүрэн, Д.Буянбаатар	Бүгд: 45 хх /Нэг дугаарын хэмжээ 15 хх /	Төвд хэлт монголын уран зохиол, утга соёлын чиглэлээр тус сэдэвт ажлын явцын үрд бий болсон шинэ мэдлэг, мэдээлэл бүхий эрдэм шинжилгээний өгүүллүүдийг эл цувралдаа хэвлүүлнэ. <ul style="list-style-type: none"> • “Төвд судлал” эрдэм шинжилгээний цуврал, Боть 06, дэвтэр 1-17, 262х, ISSN 2308-2828, 2017. • “Төвд судлал” эрдэм шинжилгээний цуврал, Боть 07, дэвтэр 1-16, 284, ISSN 2308-2828, 2018. • “Төвд судлал” эрдэм шинжилгээний цуврал, Боть 08, дэвтэр 1-14, 208х, ISSN 2308-2828, 2019. 	2017 оны III улирал 2018 оны III улирал 2019 оны III улирал
5	“Монголын эртний уран зохиолын зарим жишээ” Р.Отгонбаатар	15хх	Монголын эртний уран зохиол, хуучин соёлын өвд хамаарах, урьд өмнө судалгааны эргэлтэнд ороогүй шинээр олдсон дурсгалууд, түүний талаарх судалгааны шинэлэг бүтээл байх болно.	2019 оны III улирал
6	“Монголын бурханы шашны уран зохиол” 3 боть Д.Цэрэнсодном, А.Амарсанаа, Д.Мөнх-Отгон	15хх	Эл бүтээлд Монголын бурханы шашны үүсэл хөгжлийн түүхэн явцыг харуулсан он дараалалын бичиг хийгээд өмнөх I, II ботид ороогүй бурханы шашны утга зохиолын дурсгалуудыг задлан шинжилсэн байна.	2019 оны III улирал
7	“XX зууны монгол зохиолчид” 6 дугаар С.Байгалсайхан, Б.Мөнхбаяр, Ж.Ууганбаатар, Д.Цэвээндорж	30хх	XX зууны монголын уран зохиолын нэрт төлөөлөгчдийн намтар уран бүтээлийн судалгааны бие даасан нэг сэдэвт 6 цуврал бүтээл байна. <ul style="list-style-type: none"> • XX зууны монгол зохиолчид цуврал, 17-р боть “Чойжилын Чимид”. Д.Цэвээндорж. (6.8 хх), 2017. • XX зууны монгол зохиолчид цуврал, 26-р боть “Чойжилжавын Лхамсүрэн”. Б.Мөнхбаяр. 5 хх. 85 х, Уб., 2018. • XX зууны монгол зохиолчид цуврал, 79-р боть “Цэвэгжавын Хасбаатар”. Б.Мөнхбаяр. 5 хх. 64 х, Уб., 2018. • XX зууны монгол зохиолчид цуврал, 12-р боть “Шагдаржавын Нацагдорж” Б.Мөнхбаяр. 6 хх, Уб., 2019. • XX зууны монгол зохиолчид цуврал, 51-р боть “ П.Пүрэвсүрэн”. 	2017-2019 оны III улирал

			<p>Б.Мөнхбаяр. 6 хх, Уб., 2019.</p> <ul style="list-style-type: none"> XX зууны монгол зохиолчид цуврал, 16-р боть “Ламжавын Ванган”. Ж.Ууганбаатар. 6 хх, Уб., 2019. 	
8	<p>“XX зууны монгол романы хөгжил”</p> <p>С.Байгалсайхан</p>	12 хх.	<p>“Монгол өгүүллэгийн туурвил зүй” /1 боть/, “XX зуун Монгол тууж” /2 боть/, бүтээлийн 3 боть буюу “XX зууны Монгол романы хөгжил” гэсэн шинэ бүтээл байна. эл нэг сэдэвт зохиолд монгол романы хөгжлийн түүх, уламжлал шинэчлэл, дүр бүтээсэн туршлага, харилцаа холбоо зэрэг өргөн асуудлыг хамран судалсан байна.</p> <ul style="list-style-type: none"> С.Байгалсайхан. Реализм ба XX зууны Монгол роман, А5, 17.5 хх, ISBN 978-99978-716-6-4, 2019 он. 	2019 оны III улирал
9	<p>“Монголын утга зохиолын нэвтэрхий толь” /2 боть/</p> <p>С.Байгалсайхан, Г.Билгүүдэй, Б.Мөнхбаяр, Д.Цэвээндорж, Ж.Ууганбаатар, Д.Сумъяа, Р.Отгонбаатар, Б.Няммыгмар, Ж.Ерөөлт, Б.Лхагважав, Г.Мөнхзаяа, Г.Билгүүдэй, Д.Болормаа, А.Амарсанаа, Б.Одсүрэн, А.Алимаа, Б.Катуу, Т.Баясгалан, Б.Дайриймаа, Ч.Заяасүрэн, З.Пүрэвсүрэн</p>	10 хх	<p>Монгол уран зохиолын түүхэн хөгжлийг бүхэлд нь авч үзэж, тодруулан тодорхойлсон, монгол аман зохиол, монгол эртний уран зохиол, монголын бурханы шашны уран зохиол, орчин үеийн уран зохиол, монголын уран зохиолын уламжлал шинэчлэл, харилцаа холбоо, харилцан нөлөөлөлийн асуудлыг иж бүрэн цогцоор нь авч үзэж задлан шинжилж тайлбарлан таниулсан бүтээл байна.</p>	2019 оны III улирал
10	<p>Эрдэм шинжилгээний өгүүлэл</p> <p>Суурь судалгааны төслийн гүйцэтгэгч нэг бүр жилд 2 эрдэм шинжилгээний өгүүлэл бичнэ. Суурь судалгааны төслийн хугацаанд нийт 120 өгүүлэл гарсан байна.</p> <p>С.Байгалсайхан, Г.Билгүүдэй, Д.Цэрэнсодном, Б.Мөнхбаяр, Д.Цэвээндорж, Ж.Ууганбаатар, Д.Сумъяа,</p>	Нэг өгүүллийн дундаж хэмжээ 0.5 хх	<p>“Монгол аман болон бичгийн зохиолын түүх, уран сайхны төлөв, хэрэглээ” суурь судалгааны төслийн явцын үр дүнг мэдээлсэн, шинэ мэдлэг, шинэлэг мэдээллийн агуулга бүхий өгүүлэл байх ба олон улсын болон дотоодын ЭШ-ний нэр хүнд бүхий цуврал сэтгүүлүүдэд хэвлүүлнэ.</p> <p>Эрдэм шинжилгээний өгүүлэл: 146 Гадаад: 25 Дотоод: 121</p>	2017-2019

	<p>Р.Отгонбаатар, Б.Няммыгмар, Ж.Ерөөлт, Б.Лхагважав, Г.Мөнхзаяа, Г.Билгүүдэй, Д.Болормаа, А.Амарсанаа, Б.Одсүрэн, А.Алимаа, Б.Катуу, Т.Баясгалан, Б.Дайриймаа, Ч.Заяасүрэн, З.Пүрэвсүрэн</p>			
11	<p>Эрдэм шинжилгээний илтгэл</p> <p>Суурь судалгааны төслийн гүйцэтгэгч нэг бүр жилд 2 эрдэм шинжилгээний өгүүлэл бичнэ. Суурь судалгааны төслийн хугацаанд нийт 120 өгүүлэл гарсан байна.</p> <p>С.Байгалсайхан, Г.Билгүүдэй, Д.Цэрэнсодном, Б.Мөнхбаяр, Д.Цэвээндорж, Ж.Ууганбаатар, Д.Сумьяа, Р.Отгонбаатар, Б.Няммыгмар, Ж.Ерөөлт, Б.Лхагважав, Г.Мөнхзаяа, Г.Билгүүдэй, Д.Болормаа, А.Амарсанаа, Б.Одсүрэн, А.Алимаа, Б.Катуу, Т.Баясгалан, Б.Дайриймаа, Ч.Заяасүрэн, З.Пүрэвсүрэн</p>	<p>Нэг илтгэлийн дундаж хэмжээ 0.5 хх</p>	<p>“Монгол аман болон бичгийн зохиолын түүх, уран сайхны төлөв, хэрэглээ” суурь судалгааны төслийн явцын үр дүн бүхий шинэ мэдлэг, мэдээлэл түгээсэн эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлнэ.</p> <p>Эрдэм шинжилгээний илтгэл: 162</p> <p>Гадаад: 41 Дотоод: 121</p>	2017-2019
12	<p>Эцсийн тайланг боловсруулан хүлээлгэн өгөх</p>	1	<p>Эцсийн тайланг боловсруулан бүтээлүүд, судалгааны бүтээгдэхүүнүүдийг хүлээлгэн өгөх</p>	2019.12

“Монгол аман болон бичгийн зохиолын түүх, уран сайхны төлөв, хэрэглээ” суурь судалгааны төслийн бодит үр дүнгийн тоон үзүүлэлт:

№	Үзүүлэлт	ШуСс. 2017/68 дугаар бүхий гэрээнд	Сэдэвт ажлын үр дүнгийн биелэлт /2017-2019/
1	Нэг сэдэвт зохиол	5	6
2	“Монголын утга зохиолын нэвтэрхий толь”	2 боть	2 боть
3	Эрдэм шинжилгээний цуврал	6	6
4	“XX зууны монгол зохиолчид”	6	6
5	Эрдэм шинжилгээний өгүүлэл	120	146
6	Эрдэм шинжилгээний илтгэл	120	162

1. НЭГ СЭДЭВТ ЗОХИОЛ

1. “Ерөөлч, магтаалч Гомбын Оргойн өв”. -Эмхэтгэж удиртгал, тайлбар үйлдсэн Ч.Заяасүрэн. Редактор С.Байгалсайхан. “Соёмбо принтинг” ХХК-д хэвлэв. Уб., 2018, х.248. ISBN 978-99978-892-7-0, 2018.
2. “Монгол ардын харилцаа дуу”. -Эмхэтгэж, удиртгал, тайлбар хийсэн А.Алимаа, Б.Дайриймаа. Редактор Н.Лантуу. “Соёмбо принтинг” ХХК-д хэвлэв. Уб., 2019, 224 х. ISBN 978-9919-21-889-8
3. Т.Баясгалан. “Жангар” туулийн хувилбаруудын зэрэгцүүлсэн судалгаа” - Редактор С.Байгалсайхан. “Соёмбо принтинг” ХХК-д хэвлэв. Уб., 2019, 124 х. ISBN 978-99978-768-9-8
4. С.Байгалсайхан. Реализм ба XX зууны Монгол роман, А5, 17.5 хх, ISBN 978-99978-716-6-4, 2019 он.
5. Д.Цэрэнсодном. Монголын бурханы шашны уран зохиол, Боть 3
6. Р.Отгонбаатар. Монголын эртний уран зохиолын зарим жишээ.



1.1. Ерөөлч, магтаалч Гомбын Оргойн өв

Эмхэтгэж, удиртгал бичсэн: Ч.Заяасүрэн
Редактор: Профессор С.Байгалсайхан, Уб., 2018, 248
“Соёмбо принтинг” ХХК-д хэвлэв.
ISBN 978-99978-892-7-0

Монголын говь нутгаас олон алдартай ерөөлч, магтаалч төрсөн байдаг. Тэдний нэг бол Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын харьяат цэцэн билигт, уран яруу хэллэгт ерөөлч, магтаалч Г.Оргой агсан билээ.

Түүний зохиол бүтээлийн дээжийг эмхэтгэж “Ерөөлч, магтаалч Гомбын Оргойн өв” номыг хэвлэн нийтэлж олны хүртээл болголоо. 2009 онд түүний хэлсэн 23 ерөөлийг ахмад багш Ц.Батсуурь эмхэтгэж “Айлтган барих ерөөл” нэрээр хэвлэн нийтэлж олны хүртээл болгож байсан билээ. Тэгвэл энэ удаад уг номд ороогүй ерөөлчийн өөрийн бичиж үлдээсэн гар бичмэл өвийн хуулбар нийт 4 дэвтэрт хадгалагдаж байсан ерөөл-20, зүйр цэцэн үг-129, оньсого-6, аман шог-54 зэрэг монгол аман зохиолын төрлүүдийг өмнө хэвлэгдсэн ерөөлүүдтэй хамт ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “МОНГОЛ АМАН ЗОХИОЛЫН ЧУУЛГАН” цувралын 45 дахь ботийг “Ерөөлч, магтаалч Гомбын Оргойн өв” нэрээр хэвлэн гаргалаа. Ингэхдээ түүний хэлсэн ерөөл, магтаалыг агуулгаар нь үндсэн 5 хэсэгт хувааж, ерөөлчийн уран чадвар, ерөөл, магтаалын уран дүрслэлийн онцлогийг тодруулсан байна.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг цувралд Гомбын Оргойн ерөөл магтаал, бусад өвийг оруулж хэвлэснээр түүний ерөөл магтаал болон бусад уран бүтээлийн өв нь дотоод, гадаадын судлаач эрдэмтдийн судалгаа, шинжилгээний хэрэглэгдэхүүн болж эрдэм шинжилгээний эргэлтэд орох, илүү өргөн хүрээнд тархах, ингэснээрээ ерөөл магтаалын үнэ цэнийг цаашид улам өргөх зэрэг олон талын ач холбогдолтой юм.



1.2. Монгол ардын харилцаа дуу

Эмхэтгэж, удиртгал, тайлбар хийсэн А.Алимаа, Б.Дайриймаа. Редактор Н.Лантуу. Уб., 2019, 224 х.
“Соёмбо принтинг” ХХК-д хэвлэв.
ISBN 978-9919-21-889-8


Монгол улсын Соёлын тэргүүний ажилтан, ахмад уран бүтээлч, дуучин, хөгжимчин Нанзадын Лантуугийн 1000 шахам цуглуулга, урын сангаас зөвхөн харилцаа дууг дээжлэн эмхэтгэжээ. “Уртын дуу”, “Богино дуу”, “Хошин шог харилцаа дуу”, “Эмгэнэлт харилцаа дуу”, “Мэтгэлцээ дуу” хэмээн ангилан оруулсан нийт 47 дуунаас бүрдэл болсон байна. Монгол ардын харилцаа дууг тэмдэглэх болоод судалгаагаа нэлээд эрт цагт эхэлжээ. Монгол орноор аялан явж байсан гадаадын монголч эрдэмтэд олон тооны харилцааг дууг бичин тэмдэглэж аваад ном бүтээлдээ оруулж байв. Тухайлбал, А.М.Позднеевийн 1880 онд хэвлүүлсэн “Образцы народной литературы монгольских племен” номын Монголчуудын ардын дуу номд “Өвгөн шувуу хоёр” дууны үгийг оруулж номын 97-100 дахь талд орчуулга болоод уг дууны тухай тайлбарлан бичжээ. Монголын судлаачдаас анх түрүүнд эрдэмтэн зохиолч Э.Оюун “Монгол ардын харилцаа дууны зүйлээс”

эмхэтгэлийг 1960 онд “Монгол судлал” цувралаар эрхлэн гаргасан билээ. Уг номд Сумъяа ноён, Шаргын говийн ялаа, Сүнжидмаа (Ганцаарал дуу), Ванлий, Торой банди зэрэг 14 дуу орсон байдаг. Түүнээс хойших хэд хэдэн түүвэр хэвлэгдэн гарсан. Тухайлбал, 1959 онд “Говь, Хангайн залуучуудын наргиант харилцаа дуу” (Редактор Ч.Бадамхатан), 2005 онд Т.Батхуягийн “Монгол ардын домогт харилцаа дуу”, 2015 онд доктор Л.Хэрлэнгийн “Монгол харилцаа дууны зуун дээж”, Л.Баяр-Эрдэнийн “Монгол ардын харилцаа дуу” зэрэг эмхэтгэл түүврүүд гарчээ.

Харилцаа дуу нь “ихэвчлэн хайр сэтгэл, янаг амрагийн явдлыг илэрхийлж байсан тул 1932 онд МАХН-ын Төв хорооны тогтоолоор “Сүнжидмаа”, “Хандармаа”, “Хэен хуар”, “Аргагүй амраг”, “Ванлий”, “Сумъяа ноён”, “Хөх торгон дээл” зэрэг тавь гаруй дууг өнгөрсөн нийгмийн үлдэгдэл, феодлын дуу, завхай дуу гэх шалтгаанаар дуулахыг хориглож байжээ. Гэсэн хэдий ч эдгээр дуу ард түмний сэтгэлээс мартагдалгүй дуулагдсаар иржээ.

Монгол ардын зан үйлийн яруу найраг, аялгуут жүжгийн үндсэн хэлбэр бол харилцаа дуу бөгөөд олон түмний аж байдлаас урган гарч нийгмийн үйл явдлыг тусган харуулсан тодорхой дүрүүд өөр хоорондоо харилцах байдлаар зохиомжлогдсон ардын дууны өвөрмөц хэлбэр гэж үздэг. Харилцаа дуу бүхэлдээ дуулалт жүжгийн шинжтэй төдийгүй дүрийн гол илэрхийлэл, “яриа” болох нь олонтоо. Харилцаа дуу бол тодорхой дүр, тэдний хоорондын харилцаагаар гол утга нь илрэх бөгөөд хоёр буюу түүнээс олон хүн харилцан дуулж, жүжиглэх, бүжиглэх зэрэг цогц урлагийн шинжийг агуулна. Мөн домогжсон болон түүхэн бодит үйл явдалтай холбоотой олон дуу бий. Энэ мэт харилцаа дууны онцлогийг харуулахуйц жишээнүүдийг эмхэтгэн энэхүү номыг хэвлүүлжээ.

Номын гол онцлог бол нэг ардын авьяастны урын сан, тодруулбал Дорноговь аймгийн театрын тайзнаа 1950 оноос эдүгээ хүртэл Н.Лантуу гуай өөрөө дуулж, хөгжимдөж, гол дүрд нь жүжиглэн тоглож байсан харилцаа дуундаа тулгуурласан бөгөөд зөвхөн говь нутагт дуулагдаж байсан хэд хэдэн дуу багтав. Тэдгээр дуу нь ардын аман яруу найргийн судалгааны чухал хэрэглэгдэхүүн юм. Мөн ноотыг нь оруулжээ.



1.3. Жангар туулийн харьцуулсан судалгаа

Зохиогч Т.Баясгалан,

Редактор С.Байгалсайхан УБ., 2019, 124 х.

“Соёмбо принтинг” ХХК-д хэвлэв.

ISBN 978-99978-768-9-8

Сэдэвт ажлын төлөвлөгөөнд 2017-2019 онд гүйцэтгэж хэвлэлд шилжүүлэхээр туссан “Жангар туулийн хувилбаруудын харьцуулсан судалгаа” (10 хх) нэг сэдэвт бүтээлийг заасан хугацаанд амжилттай бичиж дуусгалаа. Энэ бүтээлийн зорилго нь 1978 оноос хойш гучаад жилийн хугацаанд Шинжааны монголчуудаас тэмдэглэж авсан Жангар туулийн 157 бүлгийг харьцуулан судалж хэдэн бүлгийн хэдэн хувилбар байгааг тогтоох, түүнчлэн гарал үүслийн хувьд хэдий үед хамаарах бүлгүүд байгааг тодруулах шаардлага тавигдаж байгааг үндэс болгож, нэгдүгээрт Шинжааны «Жангар»-ын бүлгүүдийн бүрэлдэхүүнийг тодруулах, хоёрдугаарт гарал үүслийг тодруулахыг хичээсэн болно.


Энэ бүтээлд судалгааны эх хэрэглэгдэхүүнээр «Баянголын Жангар» номын I, II ботид хэвлэгдсэн 40 бүлэг, С.Баттулгын Улаанбаатар хотноо 2014 онд нийтлүүлсэн «Илийн өөлд нутгийн туульчдын хайлсан Жангарын бүлгүүд» номд буй 21 бүлэг, профессор Д.Таяагийн нийтлүүлсэн «Жуунайн гар бичмэл Жангар» номд хэвлэгдсэн 15 бүлэг, Аримпилын «Жангар»-ын 23 бүлэг, «Хөр Хар-Усны торгууд Жангар» номд буй 4 бүлэг, нийт 88 бүлгийг хамруулан судалсны үндсэн дээр Шинжааны монголчуудын дунд Хонгор, түүний хүү Хошуун-Улааны алдар гавьяаг харуулсан бүлгүүд нь хамгийн эртний уламжлалтай, гарал үүслийн хувьд Харголын халимаг, Ижил мөрний халимагууд, Монголд дэлгэрсэн бүлгүүдтэй гарал нэгтэй байна. Шинжаанд халимагийн жангарч Э.Овлайн дэг сургуульд хамаарах бүлгүүд уламжлагдаагүй. Харин XX зуунд Э.Овлайн бүлгүүдийн хэвлэлүүд Шинжаанд дэлгэрсний улмаас бичиг номоос гаралтай Жангарын аман уламжлалт бүлгүүд ихээхэн дэлгэрсэн гэж дүгнэжээ. Энэ бүтээл бол Жангарын туулийн Халимаг, Монгол, Шинжааны хувилбаруудыг анх удаа өргөн хүрээнд харьцуулж үзсэн бүтээл болсоноороо онцлогтой.



1.4. Реализм ба XX зууны Монгол роман

Зохиогч С.Байгалсайхан, А5, 17.5 хх, ISBN 978-99978-716-6-4, 2019 он.

“Реализм ба XX зууны Монгол роман”. 2019. Тус бүтээлийн “Удиртгал” хэсэгт монгол роман, түүний уламжлалыг шинжилсэн монголын болоод гадаадын эрдэмтдийн судалгааны амжилт мөхөсдлийг нягтлан шүүсний дээр “Тэргүүн бүлэг”-тээ монгол романы бүрэлдэн буй болсон тогтолцоог дэлгэрүүлэн үзсэн. XX зуунд зуугаар тоологдох монгол роман гарсны дотор Б.Ринчен, Д.Намдаг, Ч.Лодойдамба нарын туульс онцгой байр суурь эзлэх тул тэдгээрийг реализмын арга урсгалтай холбон гүнзгийрүүлэн шинжилжээ. Л.Түдэв, С.Удвал, Ж.Пүрэв, С.Дашдооров, Ж.Бямба нарын арав гаруй зохиолчийн романыг сэдэв, дүр дүрсэлгээ тэргүүтний үүднээс задлан шинжилж, Ц.Хасбаатар, С.Лувсанвандан, Д.Цэнд, Ц.Мөнх, Г.Жамсранжав, Г.Ринчинсамбуу, Ч.Билигсайхан нарын зэрэг судлаачдын тухайлсан зохиолын талаарх үзэл бодолд өөрийн нотолгоо баталгааг ул үндэстэйгээр нээн тодруулсан байна.



1.5. Монголын бурханы шашны уран зохиол, Боть III, 15 хх, Зохиогч Д.Цэрэнсодном. Эл бүтээлд Монголын бурханы шашны үүсэл хөгжлийн түүхэн явцыг харуулсан он дараалалын бичиг хийгээд өмнөх I, II ботид ороогүй бурханы шашны утга зохиолын дурсгалуудыг задлан шинжилсэн байна. Тус бүтээл нь:

Удиртгал

1. Тахил төгсгөлийн шүлэг
2. Монгол уншлагын магтаал
3. Сургаалийн шүлэг дуулал
4. Гүр дуу
5. Индекс
6. Ном зүй
7. Хавсралт

гэсэн бүтэцтэй хэвлэгдэхэд бэлэн болоод байна.



1.6. Монголын эртний уран зохиолын зарим жишээ, 15хх, Зохиогч Р.Отгонбаатар. Бурхан багш, Богд лам, Өндөр гэгээн гурав бол Энэтхэг Төвд Монгол их хөлгөний шашинтай гурван улсын ард олны өнө эртний шүтээн болсон тодорхой түүх намтартай бурхны шашныг үүсгэн дэлгэрүүлж түүчээлэгч нар юм. Эдгээр дээдсийн намтар товч хураангуй хэдэн шүлгээс эхлээд машид дэлгэрэнгүй том том боть хэмжээтэй эртнээс эдүгээ хүртэл удаа дараалан барлаж хэвлэн бичиж зураглан түгсээр ирсэн билээ. Гэвч орчин цагийн соёлт хүмүүс том намтрыг тогтмол үзэх цаг боломж бага, бага намтрыг үзэвч товч агуулгыг уншлагын ном мэт цээжилсэн ч жинхэнэ аж төрөл, үйл хэрэг, тус эрдмийг нь төдийлөн ойлгох боломжгүй юм. Учир иймд ихэс дээдсийн намтрын зүрхэн шимийг багтаасан дундаж хураангуй намтрыг мэргэд чухалчлан эртнээс туурвисаар иржээ. Ийм дундаж хэмжээний эрхэм сайхан намтрыг монгол мэргэд монгол хэлээрээ туурвин зохиож хулсан үзэг хялгасан бийрээр хуулан бичиж, модон бараар хэвлэн түгээж байв. Өнөөгийн монголын залуус өв соёл, уламжлалт шашин, тэдгээрийн тэргүүн тэргэн замыг хөтлөн заагч Бурхан багш, Богд лам, Өндөр гэгээн зэрэг мэргэдийн товч тодорхой намтрыг үзэж унших сонирхол хэрэгцээ байсаар аж. Тиймээс ч Бурхан багш, Богд лам, Өндөр гэгээний дундаж хэмжээний намтрыг жирийн уншигч олны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нэгэн хамтад эмхэтгэн хэвлүүлэх нь үзэж сонирхох улсад тус нэмэртэй юм. Эдгээр дундаж хэмжээний гурван дээдсийн намтар нь Буриад монгол, Хошууд монгол, Халх монгол хүний монгол хэлээр туурвин зохиосон бүтээл болохын хувьд эх бичиг, сурвалж судлал, утга зохиолын судлалд үнэ цэнтэй дурсгалд тооцогдох нь зүйн хэрэг хийгээд урьд өмнө хараахан судлагдаж, нийтлэгдэж байгаагүй тул чухал ач холбогдолтой юм.

2. МОНГОЛЫН УТГА ЗОХИОЛЫН НЭВТЭРХИЙ ТОЛЬ

“Монгол аман болон бичгийн зохиолын түүх, уран сайхны төлөв, хэрэглээ” үндсэн сэдэвт ажлын хүрээнд “Монголын утга зохиолын нэвтэрхий толь” (2017-2019)-ийг төлөвлөгөөний дагуу бичиж 2019 оны II хагаст дуусгаад байна (238.25 хх).

Тус толийн редакцийн зөвлөлд Ерөнхий редактор Доктор (Sc.D), профессор С.Байгалсайхан, Салбарын редактор: Доктор (Ph.D), профессор Г.Билгүүдэй (Монголын эртний уран зохиол), Доктор (Ph.D), дэд профессор Д.Сумьяа (Төвд хэлт утга зохиол), Доктор (Ph.D) А.Алимаа (Монгол аман зохиол), Доктор (Ph.D) Б.Мөнхбаяр (Орчин үеийн утга зохиол), Уран сайхны редактор: Доктор (Ph.D), дэд профессор Д.Цэвээндорж, Техник редактор: Доктор (Ph.D) Д.Болормаа, (Докторант) Ж.Ууганбаатар нар ажиллаж байна.

Тус нэвтэрхий толь нь нийт 4396 толгой үг, ухагдахууныг багтаасан бөгөөд зохиогчдын бүрэлдэхүүнд: С.Байгалсайхан Доктор (Sc.D), профессор, Г.Билгүүдэй Доктор (Ph.D), профессор, Д.Сумьяа Доктор (Ph.D), дэд профессор, А.Алимаа Доктор (Ph.D), Б.Мөнхбаяр Доктор (Ph.D), Д.Цэвээндорж Доктор (Ph.D), дэд профессор, Д.Болормаа Доктор (Ph.D), Т.Баясгалан Доктор (Ph.D), Ч.Заяасүрэн Доктор (Ph.D), Б.Дайриймаа Доктор (Ph.D), А.Амарсанаа Доктор (Ph.D), Ж.Ууганбаатар (докторант), Х.Бираасүрэн (докторант), Д.Мөнх-Отгон (докторант), Г.Батмөнх (магистр), Д.Буянбаатар (магистр), Б.Мөнх-Эрдэнэ (магистр), Э.Оюунтунгалаг (магистрант) нар ажилласан болно.

“Монгол утга зохиолын нэвтэрхий толь” бүтээлийн ач холбогдол нь:




- Монгол улсад анх удаа үндэсний утга зохиол, уран сайхны сэтгэлгээний хөгжлийн түүхийг нэгдсэн тогтолцоонд нь авч үзэж, үнэт зүйлийг нь тодорхойлж, үнэлж дүгнэж байр суурийг нь эзлүүлж байгаагаараа
- Зөвхөн Монголын уран зохиол бус нийт монгол туургатан хийгээд өрнө дорнын соёлын нэгдмэл харилцаа хүрээнд уламжлал шинэчлэлийн хандлага, явцыг тодруулж өгч байгаагаараа
- Монгол үндэстний соёл танин мэдэхүйн сэтгэлгээний түүхэн хөгжил, шинэчлэлт чанар, нийгэм гоо зүй уран сайхны үнэлэмж хэрхэн хөгжсөнийг нээн харуулж байгаагаараа
- Зөвхөн бичгийн уран зохиол бус аман зохиол аман

соёл болон дэлхийн утга зохиолын түгээмэл хандлагатай анх удаа зэрэгцүүлэн үнэлж байгаагаараа

- Сургалт судалгаа заах арга бүх нийтийн утга зохиолын боловсролыг ахиулан дээшлүүлэх талаараа ач холбогдолтой бүтээл юм.


3. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦУВРАЛ

Аман зохиол судлалын салбараас эрхлэн гаргадаг “Аман зохиол судлал” цувралын XXXVIII, XXXIX, XL ботийг хэвлүүлэв. Цувралын ботиудад Монгол Улс, БНХАУ, Унгар, ОХУ-ын судлаачдын монгол аман зохиолын бүхий л төрөл зүйлийг хамарсан.




3.1. XXXVIII боть. “Аман зохиол судлал” цувралын XXXVIII ботийг 2017 оны 10-р сард хэвлүүлсэн болно. Энэ ботид Монгол Улс, БНХАУ, БНСУ, ОХУ-ын эрдэмтэн судлаачдын бичсэн монгол аман зохиолын онол болоод дүрийн судалгаанд холбогдох эрдэм шинжилгээний өгүүллүүд нийтлэгдлээ. Монгол аман зохиолын дүрийн үүсэл төлөвшил, бүтэц онцлог зэргийг уламжлал, зан үйлийн орчин, түүхэн зүйн зарчмын үүднээс авч үзсэн эрдэм шинжилгээний өгүүллүүдийг цогц байдлаар бэлтгэсэн нь энэхүү дугаарын онцлог юм. Мөн харьцуулсан болон орчин үе дэх аман зохиолын хэрэглээ, хэрэгцээ, өгүүлэмж гэх мэт онол-практикийн

нарийн асуудлыг хөндсөн судалгаа, орчуулга, бүтээлийн шүүмж, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын мэдээг нийтэлсэн болно. Цуврал бичгийн энэхүү дугаарыг Монгол Улсын төрийн шагналт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич Пүрэвийн Хорлоогийн мэндэлсний 100 жилийн ойд зориулав.



3.2. XXXIX боть. 2018 он. “Аман зохиол судлал” цувралын энэ ботид Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын эрдэмтэн судлаачдын бичсэн монгол аман зохиол түүний дотор тууль, дуу, үлгэр, домгийн судалгаанд холбогдох эрдэм шинжилгээний өгүүллүүд болоод орчуулга, тэмдэглэл, эрдэм шинжилгээний хурлын мэдээ, шинэ номын мэдээг нийтэлсэн болно. Цуврал бичгийн энэ дугаарыг Монголын шинжлэх ухааны байгууллагын ууган зүтгэлтний нэг, хэл утга зохиол судлаач, нэрт эрдэмтэн, Д.Нацагдоржийн шагналт Балданы Содномын

мэндэлсний 110 жилийн ойд зориулав.



3.3. XL боть. “Аман зохиол судлал” цувралын энэ ботид Монгол Улс, ОХУ, БНСУ, АНУ, БНХАУ-ын эрдэмтэн судлаачдын бичсэн монгол аман зохиолын онол түүх, бэлгэдэл зүй, зан үйл, тууль зэрэг монгол аман зохиолын олон төрөл зүйлийг хамарсан эрдэм шинжилгээний өгүүллүүд багтжээ. Эрдэм шинжилгээний өгүүллүүд нь харьцуулсан болон онол, хэрэглээ, орчин үеийн аман зохиолын судалгаанд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга зам, схем, дүгнэлт, баталгаа, тооцоо зэргийг агуулжээ. Сэтгүүлд орчуулга, тэмдэглэл гэх мэт буланд шинэ мэдээ мэдээллийг нийтэлжээ.



3.4. “Төвд судлал”. Боть 06. Дэвтэр 1-15. 4А-ийн 233 нүүр буюу 26,0 хх. 2017.


1. Эрдэм шинжилгээний өгүүлэл, 2.Эрдэм шинжилгээний шүүмж, 3.Мэдээ мэдээлэл гэсэн 3 хэсгээс бүрдэж байна. Эрдэм шинжилгээний өгүүлэл хэсэгт доктор(Sc), профессор С.Дуламын “Бодь мөрийн зэргийн” судалгааг “тахилын өгүүллээс” эхлэх нь (лагшин, зарлиг, таалал), Л.Тэрбиш, Т.Чулуун-Эрдэнэ нарын “Догон пагва Лодойжанцан Монголын Юань гүрэнд шашин ном дэлгэрүүлсэн үйлсийн товч”, ОХУ-ын профессор Сурун-Ханда Д. Сыртыповагийн “Буддын шашны монгол уран зураг” (XVII зууны сүүл – XVIII зууны эхэн үе), БНХАУ-ын профессор Ван Мандугагийн “Зохист аялгууны толь”, түүний монгол тайлбаруудын тухай судалгааны тойм,

Р.Отгонбаатарын “Буриадын Эгэтийн дацангийн төвд бар хэвлэлийн тойм”, Д.Сумъяагийн “Монголчуудын “Дара эхийн уг гарвал, тус эрдэм”-ийн тухай зохиолууд”, Б.Энхээгийн “Уданаварга” ба “Дармапада” шастирын монгол уламжлал ба дэлгэрэлт, БНХАУ-ын доктор С.Бадамцэцэгийн “Шар тууж”-ийн хэлэнд туссан төвд хэлний нөлөө”, Х.Даваапилийн “Хөгжмийн шастирын хоёрдугаар бүлэгт хийсэн зарим ажиглалт” Х.Бираасүрэнгийн “Үсгийн хүртгэл” ба түүний тайлбар, Н.Бизьяагийн “Эрдэнэ хонжины орчуулсан “Нууц хураангуй үндэс”-ийн санскрит үгийн сангийн онцлог”, Ц.Нарангэрэлийн “Жадамба”(Найман мянгат) судрын бар, төгсгөлийн үгийн тухай”, Д. Мөнх-Отгоны “Жалзэ тэмбан Ганжуурын гарчиг” гэсэн төвд хэлт утга зохиол, судар сурвалжийн судалгааны эрдэм шинжилгээний шинэ өгүүллүүд оржээ. 2. Эрдэм шинжилгээний шүүм гэсэн хэсэгт БНХАУ-ын доктор Юань Чэний “Монголчуудын төвд хэлний зохиолын онол: одоохич тайлбарлал хийгээд онолын цогцлол” (Шу Линий “Монголчуудын төвд хэлэн дээрх утга зохиолын онолын тогтолцоо” гэх номын үнэлэлт), Д.Сумъяагийн “Найман тойн Жамбалдоржийн намтар судлал” номын тухайд” гэсэн шинэ судалгааны номын тухай шүүмжүүд оржээ.



3.5. “Төвд судлал” сэтгүүл. Боть 07 /А4 цаасаар 230 нүүр/ 2018 оны дугаарыг бэлтгэж хэвлэлд шилжүүлэв. Сэтгүүлийн хэвлэлийн эхийг Д.Буянбаатар, хураангуйг Х.Бираасүрэн англиар орчуулав.

Энэхүү ботийг Монгол Улсын Төрийн гурван удаагийн шагналт, Ардын уран зохиолч, Академич, Төвд судлалын салбарыг санаачлан үүсгэн байгуулагч Цэндийн Дамдинсүрэнгийн мэндэлсний 110 жилийн ойд зориулав.





3.6. “Төвд судлал” сэтгүүл. Боть 08. Уб., 2019.

Ботийн ред Д.Сумъяа. Цахим эхийг бэлтгэсэн Б.Буянбаатар. Төвд хэлт утга зохиол судлал болон төвд судар сурвалжийн судалгаанд зориулсан энэхүү сэтгүүлийн 08 дахь ботид Монголын төвд судар сурвалжаар ажилладаг С.Дулам, Л.Тэрбиш, Д.Бүрнээ, Р.Отгонбаатар болон гадаад дотоодын төвд судлалын чиглэлийн судлаач эрдэмтдийн эрдэм шинжилгээний шинэ өгүүлэл хэвлэгдсэн байна.

XX ЗУУНЫ МОНГОЛ ЗОХИОЛЧИД

1. XX зууны монгол зохиолчид цуврал, 17-р боть “Чойжилын Чимид”. Д.Цэвээндорж. (6.8 хх), 2017.
 - Ч.Чимэд нь XX зууны Монголын гарамгай зохиолч, нэрт орчуулагч, иргэний уянгын яруу найргийн томоохон төлөөлөгч, яруу сайхны сэтгэлгээг өргөжүүлсэн уран бүтээлч юм. Тэрбээр Монголын шинэ үеийн утга зохиолыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан зохион туурвигч, нийгмийн зүтгэлтэн /дипломатч/, соён гэгээрүүлэгч тул энэхүү бичмэл ном “Чимэд судлал”-д тодорхой хувь нэмэр оруулах бүтээл юм.
